



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 8/196

Ховд


Худалдан авах ажиллагааны газрын бүтэц
орон тооны нэршилд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 312, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 526 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн A/775 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан Худалдан авах ажиллагааны газрын бүтэц орон тооны 4,7,8 дахь албан тушаалын нэршлийг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолын Албан тушаалын тодорхойлолтын нэршлийн дагуу өөрчлөн хавсралтаар баталсугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Худалдах авах ажиллагааны газрын дарга (Н.Эрдэнэцэцэг)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 0557
Zah A/196 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
A/196 дугаар захирамжийн хавсралт



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
БҮТЭЦ ОРОН ТООНЫ НЭРШИЛ

№	Албан тушаалын нэршил	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
2	Хуулийн мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
3	Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1

-оOo-